

Дарьгангын “Жороо нь жороо” уртын дуунд хийсэн зарим ажиглалт

Сэнгээгийн Цолмон 

“Сити” их сургуулийн Урлагийн сургууль, Улаанбаатар, Монгол Улс

✉ tsolmon2686@gmail.com

Хураангуй: Монгол ардын уртын дууны далай их сангийн нэгэн жигүүр, цутгалан нь болох Дарьгангын уламжлалт уртын дууны өвийн судалгаа төдий л элбэг бус аж. Энэхүү угсаатны уртын дууны өв, соёл мартагдан бүдгэрэх хандлага ажиглагдаж, цөөн тооны дууны хүрээнд л урын сан нь эргэлдэх болжээ. Дарьгангын “Жороо нь жороо” уртын дууны зарим онцлог шинжийг тодруулж, судалгааны эргэлтэд оруулах, энэ дууны түүхэн домог болон дуулсан дуучид, өвлөн уламжлагчдын түүх намтрыг тодруулах, дуулсан хувилбарын зарим онцлог шинж, дууны тархсан байдлыг тодорхойлох оролдлого хийлээ. “Жороо нь жороо” дуу нь дарьгангачуудын дунд өргөн дэлгэр тархахдаа нутгийн ардын авьяастнуудаар уламжлагдан аялгууны цөөн бус хувилбараар дуулж иржээ. Өөр хоорондоо ойролцоо шүлэгтэй боловч, дууны нэр болон аялгууны ялгаатай төрх нь халх болон ойрадуудын дунд бас тархсан байна.

Дарьгангын уртын дууны судалгаа нь Монголын зүүн аймгийн бүсэд урт дуу дуулах онцлогийг тээн, илэрхийлж байдаг билээ. Энэхүү судалгааны өгүүлэл нь Зүүн монголын хөгжмийн өв соёлын нэгэн ай болсон уртын дууг “Жороо нь жороо” дуугаар төлөөлүүлэн таниулж, түгээн дэлгэрүүлэхэд ач холбогдолтой хэмээн үзнэ.

Түлхүүр үгс: монгол ардын уртын дуу, дууны хувилбар, Жороо баахан улаан, айзам дуу

Some observations on the Dariganga long song “Joroo n Joroo”

Tsolmon Sengee 

School of Arts, Citi University, Ulaanbaatar, Mongolia,

✉ tsolmon2686@gmail.com

Abstract: There is a lack of research on the traditional long songs of the Dariganga people, which constitute a key element of Mongolian folk music. The historical legacy of some of these songs appears to be gradually fading, and the existing repertoire has been reduced to only a few surviving pieces. This study aims to clarify the characteristics of the Dariganga long song “Joroo n Joroo” and integrate it into academic discourse by exploring its historical background, the singers who have performed it, and the

biographies of key heritage bearers. The song became widely known among the Dariganga community, having been passed down through generations of local folk singers and performed in different versions. Although the lyrics remain similar, the song has been transmitted among the Khalkh and Oirat people, where it appears with changes in melody and title.

The study of “Joroo n Joroo” highlights the distinctive characteristics of long song singing in Mongolia’s Eastern Province. This article contributes to the documentation and promotion of the long song tradition, which remains an essential component of the musical heritage of Eastern Mongolia, as exemplified by the song “Joroo n Joroo.”

Keywords: *mongolian long song, song versions, Joroo baahan ulaan, aizam song*

Оршил

Дарьганга нутгийн ардын дууг судалсан байдлыг ажиглахад, урт болон богино дуунуудын шүлэг, хэл соёлын онцлог болон дарьганга ардын богино дууг голлон авч үзсэн тун цөөвтөр тооны судалгааны бүтээл байх аж. Зарим дуучид, өвлөн уламжлагчдын дуулсан “Жороо нь жороо” дууны ур хийц, донж маягтай холбоотой түүхэн онцлогийг тодруулахын зэрэгцээ нутгийн ард түмний дунд хэрхэн уламжлагдан дуулагдаж ирсэн байдал, мөн энэ дууны хувьд өмнө нь хөндөж байгаагүй дууны үг болон аяны хувьд төстэй хувилбаруудын тархалтыг тодрууллаа. Судалгааны явцад энэ дуу нь Дарьгангын ард олны дунд тархан дуулагдаж ирсэн нэгэн чухал өв болох нь харагдаж байна.

Судалгааны арга зүй

Ажиглалт, харьцуулалт, ярилцлагын арга, хөгжмийн бүтцийн анализ, угсаатны судлалын аргуудыг ашиглав. Ингэхдээ “Жороо нь жороо” дууны ая – аялбар – тухайлбарын ерөнхий болон нарийвчилсан бүтцийг хөгжмийн анализын арга ашиглан гаргаж, тодорхой үр дүнд хүрэв. “Жороо нь жороо” дууны ая аялгуу, шүлгийн бүтцэд ажиглалтын аргыг ашигласан зэрэг шинжлэх ухааны арга зүйг ашиглав. Дууны зарим өвлөн уламжлагчидтай ярилцлага хийж хэрхэн уламжилсан тухай тодруулав.

Судалгааны үр дүн


Дарьгангын уртын дууг зүүн аймгийн буюу монголын зүүн зүгийн халх дэг барилд хамаатуулж байгаа болно. Дарьгангын уртын дууны цэгцтэй судалгаа, мэдээлэл ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн архивт бүртгэгдсэн 1960-1990 онд хээрийн шинжилгээний ажлаар цуглуулсан уртын дууны жагсаалт – нэрс, мэдээллийн сан, уртын дуу судлаач, доктор А.Алимаагийн олон жилийн судалгаа зэрэгт тусгалаа олжээ (Алимаа, Ганболд, Идэрбат 2023, 23).

Мөн МУАЖ Ш.Чимэдцэеэгийн “Жаахан шарга” Дарьганга, Үзэмчин уртын дууны эмхэтгэлд үг ноотны хамт орсон дарьгангын 10 орчим уртын дуу, мөн дуучны “Дарьганга зүгийн эгшиглэн” цомогт багтсан уртын дуунууд голлох чухал байр суурийг эзэлж байна. Уртын дуучин Ж.Дорждагва 1970 онд хэвлэсэн “Уртын дуу” номд “Жороо нь жороо” дууг оруулж, эгшиг тэмдэглэгээнд буулгахдаа “Дарьганга нутгийн аялгуугаар” гэсэн тодотголыг хийсэн байна (Дорждагва 1970, 94).

МУАЖ, доктор Ш.Чимэдцэеэ “Жаахан шарга” Дарьганга, Үзэмчин ардын дууны түүвэртээ 1995 онд “Жороо нь жороо” дууг өөрөө дуулсан хувилбартаа түшиглэн, эгшиг тэмдэглэгээнд буулгасан (Чимэдцэеэ 1995, 180) бол, уртын дуучин, судлаач Ц.Туяацэцэг “Хуур магнай эгшиг” монгол уртын дууны түүвэртээ 2021 онд МУАЖ Ч.Шархүүхэний дуулснаар ноотлон буулгаж (Туяацэцэг 2021, 140), тус тус хэвлэжээ.

Сая дурдсан Ш.Чимэдцэеэ болон Ч.Шархүүхэн нарын дуулж, хөгжмийн бичигт тэмдэглэсэн хувилбарууд нь бүгд дарьгангын аялгуугаар буусан хувилбарууд боловч, аялгууныхаа зураглалын хувьд өөр өөр байгаа юм. Эндээс үзвэл, хэдий нэг нутгийн аялгуугаар дуулсан хувилбарууд боловч тухайн нутгийн хаана хаана дуулагдаж байснаараа өөр байгаа нь ажиглагдаж байна. “Жороо нь жороо” уртын дууг дуулсан бичлэгүүд МҮОНР-д МУАЖ Ч.Шархүүхэн, МУАЖ Ш.Чимэдцэеэ, ардын авьяастан, өвлөн уламжлагч Ц.Бүрзмаа нарын дуулснаар хадгалагдаж байна.

МУАЖ Ш.Чимэдцэеэгийн дуулсан “Жороо нь жороо” уртын дуунд хийсэн анализ. Ш.Чимэдцэеэ өөрийн дуулсан хувилбарыг (Зураг 1) 1975 онд Дарьганга сумын Баазарын Гүнсмаагаас сурсан бөгөөд энэ дууг Зуугийн оронд эрдмийн мөр хөөхөөр явахад нь хүүдээ зориулж аав, ээж нь дуулсан дуу гэж манай нутагт ярьдаг хэмээн дурджээ (Чимэдцэеэ 1995, 41). Дууг заасан Баазарын Гүнсмаа нь тухайн нутагтаа Дарьгангын их дууч хэмээн нэрийддэг, дарьгангын алдарт шилийн сайн эр “Хангай” Базарын (нутгийнхан нь Баазар гэж авгайлдаг) охин үр аж. Тэрээр уртын дууг сайхан дуулдаг байсан бөгөөд 1905-1982 онд амьдарч байжээ (Цэеэ-Ойдов 2022, 56-66).



Зураг 1. Ш.Чимэдцэеэгийн дуулсан “Жороо нь жороо”
дууны эгшиглээс /ноот/ (Чимэдцэеэ 1995)

Жороо нь жороо

Жорооны жороо улаан шүү
Жолоогий нь дөмөөд мордоорой
Зорьсон газар хол шүү
Зориглос хийгээд мордоорой
Талын хөндий арвин шүү
Татаж тавьж яваарай
Элстийн хөндий арвин шүү
Эргээд битгий хараарай (Чимэдцээ 1995,41).

Дууны шүлгээс харахад аж байдлын, сургаалийн шинжийг агуулж байгаа учир дарьганга уртын дууны аж байдлын уянгат дууны төрөлд багтаж энэ дотроо сургаалийн уянгат дууны төрөл зүйлд ангилагдана (Чимэдцээ 2024, 26).

“Жороо нь жороо” уртын дууны аялгууны бүтцийн анализ. “Жороо нь жороо” дууны энэ хувилбар нь аялгууны бүтцийн хувьд хоёр өгүүлбэр буюу нэг мөчлөгөөс /период/ бүрдэнэ. Шүлгийн бадаг нь дөрвөн мөрөөс бүрдэж дууны нэг бадагт шүлгийн хоёр мөр дуулагдаж байна.

Эхний аялбар “Жорооны жороо” гэсэн үгтэй. “Улаан шүү” гэсэн үгсээс хоёр дахь тухайлбар – аялбар өрнөнө. Улмаар “ээ” гэсэн аялга үгээс удаах аялбар түрж, “жолоогоо” гэх үгийн өмнөх “ээ” аялгаар төгсөнө. “Жолоогоо”-оос дөрөв дэх, “өө” аялгаас тав дахь тухайлбар “өө, яваарай” гэх үгсийн хамт “си, фа” өргүүдээр өрнөн өндөрлөнө.

Аялбар буюу тухайлбар бүрийн аялгууг дараах байдлаар томъёолон үзүүлж болно. Энэ нь $(a+b+c)+(d+e+f+g+h)$ болж байна.

- Энэхүү ерөнхий бүтцээс харахад 2 өгүүлбэр, 8 тухайлбартай байгаа нь илт байна.
- Тухайлбар бүрийн аялгуу давтагдаагүй бөгөөд өгүүлбэр тус бүрийн тухайлбарын тоо хэмжээ харилцан адилгүй байгаа нь монгол ардын уртын дуунд байдаг нийтлэг хэв шинжийг хадгалж буйн илрэл юм.
- Өгүүлбэрийн хуваагдал нь суурь f /фа/ эгшигт тулгуурласан, шүлгийн хоёрдугаар мөр эхэлж байгаа зэргээс тодорхойлогдож байна.
- Доктор Д.Оюунцэцэг уртын дууны бүтцийг “Эхний хэсэг”, “Дунд хэсэг”, “Төгсгөлийн хэсэг” хэмээн гурван хэсэгт хуваасан байдаг (Оюунцэцэг 2006, 107-109). Энэ загварчлалын дагуу “Жороо нь жороо” дууг дараах байдлаар задлан шинжилж болно.

Эхний хэсэг	Дунд хэсэг	Төгсгөлийн хэсэг
1-р бадаг - $\left[\text{Жорооны жороо улаан шүү} \right]$	$\left[\text{Жолоогоо дөмөөд} \right]$	$\left[\text{яваарай} \right]$

Аялгууны цараа /диапазон/ хоёр наймцын цараатай ($as-as^2$) байгаа нь уртын дууны өргөн цараанд орно. Доктор Ц.Чулуунцэцэг “Монгол Улс дахь уртын дуу, дуучдын тархалтын судалгаа” бүтээлдээ “Судалгаанд хамрагдсан айзам уртын дуунууд нь нэг наймц долооцоос /септима/ хоёр наймц дөрөвц /кварта/ хүртэлх дөрвөн янзын цараатай болох нь тогтоогдлоо (Чулуунцэцэг 2021, 65) гээд “Айзам

уртын дууны хувьд энэ цараа нь (нэг наймц долооцын цараа) бага цараа боловч найр наадмын эхэн буюу төгсгөлд дуулагддаг гүн хүндэтгэлийн шинжтэй дуунууд юм. “Шажин түмэн эх”, “Амбан цэцэн хааны хүлэг” дуунууд нь Баянбараат аялгуутай ба тэр нутгийнхны найр наадмын эхэнд дуулагддаг гүн хүндэтгэлийн шинжтэй дуунууд юм. Бусад дуу ч мөн адил нутаг нутгийн шинж чанарыг хадгалдаг учраас айзам уртын дууны ангилалд оруулдаг байна” (Чулуунцэцэг 2021, 66) гэжээ. “Жороо нь жороо” дууны хувьд нутагтаа найрын төгсгөлд дуулагддаг, мөн аялгууны цараа нь хоёр наймц байгаа нь айзам дууны шинжийг агуулж байна. Дууны оргил /кульминация/ хэсэг нь тав дахь тухайлбарт хоёрдугаар наймцын ля бемоль дээр оргил эгшигт хүрч, мөн энэ тухайлбарт давхар шуранхайлж байгаа нь айзам урт дууны нэгэн шинжийг илэрхийлж байна.

Аялгууны хөдөлгөөн ба үсрэлтийн онцлог.

1. Огцом үсрэлтүүд ажиглагдана.
2. Дууны эхлэл хэсэгт “жорооны жороо о э ээ” гэсэн үгтэй хэсэгт бага наймцын “си”- нэгдүгээр наймцын “си” эгшигт үсрэлт,
3. Эхний тухайлбар дуусаад, “улаан” гэсэн үгтэй хоёр дахь тухайлбар эхлэх хэсэгт нэгдүгээр наймцын “си” эгшгээс бага наймцын “ля” эгшиг хүртэлх нэг наймц хоёрцын үсрэлттэй,
4. Тав дахь тухайлбараас зургаа руу шилжих хэсэгт хоёрдугаар наймцын “фа”-аас нэгдүгээр наймцын “ми” эгшиг хүртэлх нэг наймц хоёрцын үсрэлт,
5. Долоо дахь тухайлбарын эхлэлд нэгдүгээр наймцын “ми” эгшгээс хоёрдугаар наймцын “ми” эгшиг хүртэлх нэг наймцын үсрэлт зэрэг олонтоо тохиолдож байна.

Энэ тухай доктор Ш.Чимэдцэеэ “Зарим дуунд тухайлбал, “Жороо нь жороо” гэх мэт дуунд нэг наймцаас нөгөө наймц өөд, тухайлбал, доод наймцаас дээд наймц өөд дайрч бадрангуй байдлаар үсрэх хөдөлгөөн хийнэ. Өөрөөр хэлбэл, “жороо-ны жор-оо-о иээ” гэх маягаар дайрч үсэрдэг нь онцлог талтай” гэсэн байна (Чимэдцэеэ 2024, 56). Ийм холын үсрэлтүүд нь айзам дууны хувьд байх ёстой нэгэн онцлог шинж бөгөөд энэ дуунд байгаа үсрэлтүүд нь энэхүү шинжийг тодруулан тодорхойлж байна. Гэхдээ “Жороо нь жороо” дуу нь “Хуур магнай”, “Түмний эх”, “Эрхэм төр” гэх мэт томоохон бүтэцтэй, төрийн дуунуудтай харьцуулахад цар хүрээний хувьд бага, тухайн нутагтаа найр наадмын төгсгөлд дуулагддаг онцлог шинж чанартай дуу юм.

Дууны хөг, эгшиглэгээний онцлог.

1. Дууны аялгуу таван эгшигтийн эгшиглэгээтэй (лад) бөгөөд f, as, b, c, es эгшгийн дарааллаас бүрдэнэ.
2. Энэ нь таван эгшигтийн /пентатоника/ хоёрдугаар төрөл болно. Энэ төрөл нь бага хөгийн (минор) шинж чанарыг агуулж байдаг.

МУАЖ Ч.Шархүүхэн өөрийн дуулсан хувилбарыг (Зураг 2) анх Сүхбаатар аймгийн Халзан сумын иргэн Саарал, Бөөрөнхий хочит Лхамжав нараас сурчээ. Үүний дараа ардын авъяастан Цэрэндоржийн Бүрзмаагаар аялуулан заалгаж байсан байна (Ч.Шархүүхэн 2022). Ц.Бүрзмаа нь (1927-1981) тухайн үеийн Хан Хэнтийн уулын аймгийн Түвшинширээ (одоогийн Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум)

суманд төрсөн. Сүхбаатар аймгийн Уулбаян суманд 1956 он хүртэл ажиллаж амьдарч байгаад 1964 оноос Хэнтий аймагт шилжин суурьшжээ. Тэрээр Бүх ард түмний язгуур урлагийн наадамд хоёр удаа оролцон алт, мөнгөн медаль авч байснаас 1981 онд болсон урлагийн наадамд “Жороо нь жороо” дууг дуулж байсан байна. Ц.Бүрзмаа нь энэ дууг өөрийн ээж Н.Цэрэннадмидаар заалгаж байсан, ээж нь мөн өөрийн ээжээр заалгаж байжээ. Ээж Н.Цэрэннадмид нь Сүхбаатар аймгийн Уулбаян суманд насан эцэс болтлоо амьдарсан хүн юм (С.Нансалмаа 2022).

МУАЖ дуучин Ч.Шархүүхэний ярилцлагаас үзвэл, дууг заасан Саарал болон Лхамжав нар нь Сүхбаатар аймгийн Халзан сумын харьяат байгаа нь Дарьгангад хамаарах сум болохыг харуулж байна. Үүний зэрэгцээ дууг заасан ардын авьяастан Ц.Бүрзмаа болон түүний ээж Н.Цэрэннадмид болон эмээ нар нь мөн л Сүхбаатар аймгийн уугуул. Эндээс үзвэл, МУАЖ, дуучин Ч.Шархүүхэний дуулсан хувилбар дарьганга нутгийнх гэж үзэх үндэстэй байна.



ЖОРОО НЬ ЖОРОО
/Уртын дууч МУАЖ Ч.Шархүүхэний дуулснаар/

Andante

ЖОРОО НЬ ЖОРОО
Жороо нь жороо жороолно
Жолоогий нь дөмөөд яваарай
Зорьсон газар холхон
Зоригго битгий мохоогоорой

Зураг 2. МУАЖ Ч.Шархүүхэний дуулсан “Жороо нь жороо”
дууны эгшиглээс /ноот/ (Туяацэцэг 2021)

“Жороо нь жороо” дуутай төстэй бусад хувилбаруудын тухай. “Жороо нь жороо” дуутай үгийн хувьд төстэй хувилбарууд баруун халхад тухайлбал, Хөвсгөл аймгийн Галт суманд “Жороо баахан улаан”, “Архангай аймгийн Өндөр-Улаан суманд “Жороо баахан халиун”, ойрадын Мянгадад “Жороо баахан улаан”, зарим тохиолдолд “Жороо баахан халтар”, урьд хөрш болох Өвөр монголд “Жороо нь жороо” болон “Жороогийн жороо” нэртэйгээр дуулагддаг боловч аялгуу нь дарьганга хувилбараас ихээхэн өөр байна.

Монгол хэлний их тайлбар толиос харвал, “жороо” гэдэг үгийг “адуу, илжиг, луус зэрэг нэгэн зүйл явдлын нэр, нэгэн алхамдаа зүүн этгээдийн хоёр хөл, нөгөө алхамдаа баруун этгээдийн хоёр хөлийг тус тус зэрэг гишгих сайвраас хурдан явах” хэмээн тодорхойлсон байхын зэрэгцээ “жороо морь” гэсэн холбоо үгийг жороолон явдаг морь гэсэн байна.

Дарьгангын “жороо нь жороо” заримдаа “жороон жороо”, “жорооны жороо” гэж дуудагдаж бас бичигддэг энэ нэршил нь Дарьгангад жороо морь дотроо хамгийн сайн жороолдог морийг хэлдэг гэх бөгөөд дуудлага бичлэгийн хувьд нутгийнхны аялгатай холбоотой бололтой юм. Тэгвэл “Жороо баахан улаан” нэрийн “баахан” гэсэн үг нь 1. нэлээд, овоо, зэгсэн 2. хэсэг зуур, бага зэрэг 3. үл ялиг, ялимгүй гэсэн утгыг агуулж байгаагаас нэлээд, овоо, зэгсэн гэсэн утгыг харгалзуулбал нэлээд улаан жороо, зэгсэн улаан жороо гэсэн утгыг илэрхийлж байна. Ингэснээр дууны шүлгийн агуулгатай нийцүүлбэл утгын хувьд нэлээд зэгсэн улаан жороо морь гэсэн утга илэрхийлж байгаа нь дарьгангын хамгийн сайн жороолдог морь гэх утгатай дүйж байна. Иймд дуулагдаж байгаа янз бүрийн хувилбаруудын нэршил төстэй байна.

“Жороо нь жороо” дууны хувилбарууд хэвлэгдсэн байдал. “Жороо баахан улаан” монгол ардын уртын дуу нь нутаг нутагт өөрийн гэсэн онцлог бүхий хувилбарууд болон тархсаныг цаашид авч үзье.

Судлаач А.Сампилдэндэв, К.Н.Яцковская нар “Монгол ардын дуу” бүтээлдээ Хөвсгөл аймгийн Галт суманд найр хурим жаргаах дуу хэмээгээд уг дууны шүлгийн хувилбаруудыг харьцуулан үзэж, “Жороо баахан улаан” дууны 13 бадгийг нэгтгэн хэвлүүлсэн байдаг. Тухайлбал, 1-5, 8-р бадгийг Хөвсгөл аймгийн Галт сумын ард эмэгтэй Дампилын Дугаржаваас (62 настай) 1972 онд тэмдэглэн авч, 6, 7-р бадгийг “Уртын дуу” (1970) номын 39-р талаас, 9, 10-р бадгийг 94-р талд буй “Жороо нь жороо” хувилбараас, 11-13-р бадгийг Академич Ц.Дамдинсүрэнд буй “Энэ арван айзам, гучин хоёр шаштирын түлхүүр оршив” хэмээх бичмэл дэвтрээс тус тус сэлбэж авсан тухай тайлбарлажээ (Сампилдэндэв, Яцковская 1984, 251-253). “Жороо нь жороо”, “Жороо баахан улаан” хоёр дууны үг шүлгийн бүтцээс нь ажихад ихээхэн төстэй байна. Мөн “Арван гурван хүлгийн дуун” (Ойрад аман зохиолын цоморлиг) эмхэтгэлд хэвлэгдсэн байгаа хувилбарыг Ховд аймгийн Дуут сумын туульч (Урианхай) С.Чойсүрэнгээс тэмдэглэн авсан байна (Цолоо 1987, 219).

Доктор Т.Гун-Аажавын эмхэтгэсэн “Монгол ардын уртын дуу” номд “Жороо баахан улаан” (Мянгад ардын уртын дуу) нэртэйгээр үг, ноотны хамт, мөн тэнд 67-р талд өөр нэгэн хувилбар үг ноотны хамт хэвлэгдсэн байна (Гун-Аажав 2019, 66-67). 67-р талд буй хувилбарын үг нь Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская нарын “Монгол ардын уртын дуу” эмхэтгэлд дурдсан “Алтайчуудын найраг” 1970 номын 31-р талд буй хувилбартай төстэй байна.

“Хуур магнайн эгшиг” номд “Жороо баахан улаан” нэрээр уртын дууч Л.Баяр-Эрдэнийн дуулснаар, мөн тэнд 138-р талд “Жороо баахан халиун” нэртэйгээр Архангай аймгийн Өндөр-Улаан сумын аялгуугаар ноотонд буусан хувилбар үгийн хамт хэвлэгджээ (Туяацэцэг 2021, 137-138).

“Жороо нь жороо” дууны нэрээр олдож буй домгийн хувилбарууд. Дарьгангын “Жороо нь жороо” дууны шүлгийн утга агуулгатай төстэй “Жороон жороо улаан” нэртэй дууны домог дор дурдсан хоёр хувилбараар олдож байна. Үүнд, 1. Үзэмчин дууны түүхтэй холбоотой домог, 2. Цээрийн дууны домог гэх дараагийн хувилбар олдож байгаагаас дурдвал,

1. Урьд Дүйнхэр агь хошуу нутгийн өмнөөс аврал даатгал эрхээр баруун газар морилохдоо тэмээн ачаа, морин тэрэгтэй заларсан гэнэ. Дүйнхэр агид вангаас тусгай бэлтгэж өгсөн улаан бүрээс, хөх чимхээртэй хаалга цонхтой битүү хам тэрэг нь, зоо дээрээ хөх суурьтай гуулин дог, нарны халхавч бүс сэгтэй, хөллөсөн морь нь жи да монцог (хэргэм зэргийн эдлэл), хударга бүрэн, тэрэгчин нь улаан гол хатгасан таваг залаат хар тоорцог тавьж, уул усны зураг хатгамалтай хар шаахай өмсөн, шилбээн боочихоод яг л нэг хошуу захирагч морилж байх шиг ямбатай явдаг дүрэмтэй байжээ. Замын дунд нэг өдөр тэргэнд хөллөсөн жороо улаан морь нь ямар нэгнээс үргэн хөглөсөнд тэрэгчний уур хүрч морио гуядаж ширүүн явсаар оройн буудалд морио зогсоогоод хүрч гэнэ. Иймд Дүйнхэр агь хэл амгүй адгуусыг тарчилгаж цохихоор өрөвдөх сэтгэл үүсэж, алсын замыг туулах аяны хань хүлгээ хайрлаж гамнахыг тэргэгчиндээ сургахыг санаж, тэр шөнөдөө хэдэн бадаг шүлэг зохиосноо маргааш нь зам хөөж байхдаа аялгуулан дуулж өгсөн гэнэ. Аялгуулан дуулж өгсөн тэрхүү дуу нь даруй “Жороон жороо улаан “ хэмээх дуу болох ажээ.

Жороо жороо улааныгаа
Жолоог нь битгий тавиарай
Зорьсон газар холхон шүү
Зоригоо битгий мохоогоорой
Тал хөндий нь уужим шүү
Тавьж татасхийгээд яваарай
Танихгүй хүн чинь хартай шүү
Сэрэмж л сайтай яваарай
Уулын хөндий нь уужим шүү
Угзарч татасхийгээд яваарай
Уулзаагүй хүн чинь хартай шүү
Сэрэмж сайтай яваарай
Амдуу гэдэг нь хол шүү
Арван сарын газар шүү
Амдууддаа мэнд хүрэхийг
Андуугийн чойржин өршөө дөө
Гүмбэн гэдэг нь хол шүү
Гурван сарын газар шүү
Гүмбэндээ мэнд хүрэхийг
Гүмбэний чойржин өршөө дөө
Зуу гэдэг нь хол шүү

Зургаан сарын газар шүү
Зуудаа мэнд хүрэхийг
Зуугийн чойржин өршөө дөө.

Тус дууг Дэлийн Ам гэх Ламын хүрээний шаврангийн ээж хүүгээ зууд мөргөхөөр явахад нь захиж дуулсан дуу ч гэдэг билээ (Бөххад 2019, 115-117) гэсэн байна.

2. Цээрийн дуу “Жороо жороо улаан”-ы домог: Эрт урьд цагт хайр сэтгэлтэй хархүү, бүсгүй хоёр байжээ. Тэр үед ямар нэгэн албанд залууг нь томилон явуулж гэнэ. Залууг хол газар явсны хойно сэтгэлт бүсгүй нь насан өөд болжээ. Залуу хархүү алс хол явахдаа хайрт бүсгүйдээ нэгэн бөгж өгч үлдээсэн байж гэнэм. Хугацаат алба өндөрлөж залуу нутагтаа ирж, сэтгэлт бүсгүйдээ очихыг хүсжээ. Гэтэл нутгийн хүмүүс нь “Чи нутаг руу очиж болохгүй ээ! Тэр газар чинь одоо чөтгөртэй болчихсон. Чи тийшээ ёстой зүглэж ч болохгүй шүү!” гэж хэлээд тас хорьжээ. Залуу “Үгүй ээ, ямар ч байсан очих ёстой” гэж санасан сэтгэлдээ яаран боджээ. Энэ үед сэтгэлт хүүхнийх нь нутаглаж байсан нутаг тийш хүмүүс очихоо больсон байж гэнэ. Янаг хайртай бүсгүй нь түүнд “Би чинь өөд болсон шүү дээ. Чиний өгсөн бөгжийг чамд буцааж өгье гэж бодоод энэ хавиар явсан хүмүүсийг дуудахаар зугтаад явчихдаг юм” хэмээн санаа алдан хэлжээ. Ийнхүү залуу сэтгэлт бүсгүйтэйгээ тэр гэрт хоносон ажээ. Өглөө нь сэрээд хартал ганцаараа эмээлээ дэрлээд унтаж байсан гэнэ. Түүний хоносон тэр газар бол сэтгэлт бүсгүйнх нь насан өөд болсон газар мөн болохыг тэрээр тэрхэн зуур ойлгожээ. Тухайн үед залуу хархүү улаан морь унаж явсан гэнэм. Гуниг шаналандаа дарагдсан залуу тийнхүү хээр хоноод буцаж явахдаа

Жороо жороо улаан чинь
Зогсолт үгүй сайвар шүү
Зорьсон газар хол шүү

Ардаа битгий хараарай хэмээн дуулсан гэдэг. Ингэж “Жороо жороо улаан” хэмээх уртын дуу үүсэж, олон түмэнд түгэн дэлгэрсэн юм гэнэ билээ. Энэхүү дууг манай нутгийнхан хурим найр дээр дуулахыг цээрлэдэг учир нь ийм юм гэх домгийн энэ хувилбарыг Говь-Алтай аймгийн Тонхил сумын иргэн, өв тээгч Д.Донидбаатар өгүүлсэн нь “Халх Монголчуудын уртын дуу, зан үйл 1” номд тэмдэглэгджээ (Дорждагва 2018, 303-304).

Домгийн эхний сурвалж нь үзэмчин дууны домог байна. Үзэмчинд дууны дэлгэрсэн байдлыг угсаатан бүрдэл талаас нь танин судлах нь зүйн хэрэг юм. Тэгвэл үзэмчний түүхийг мөшгин үзвэл, цахартай гүн холбоотой болох нь тодорхой болсон юм. Цахар нь монголын цэрэг-захиргааны зохион байгуулалтаас буй болсон. Юань улс унаж, монголын язгууртнууд эх нутагтаа буцаж ирсний дараа үеэс л цахар хэмээх нэр түүхэнд гарч иржээ. Цахар түмэн нь хэдэн баг аймгаас бүрддэг байв. Үүнд, Хишигтэн, Зүйд, Буруд (Бүрд), Холбод, Найман, Сөнид, Үзэмчин, Хуучид, Анхан, Алагчууд, Цагаан Татар, Хэмчигүд багтаж байв. Ялангуяа Батмөнх даян хаан, түүний залгамжлагчдын цагт хааны сүр хүчин өсөж, янз бүрийн овог аймгийг хааны төвлөн суусан Цахарт нэгтгэж байжээ (Очир 2012, 90-91). Эндээс үзэхэд, цахар уртын дуу нь дээр нэр дурдсан овог аймгууд болон үзэмчин уртын дууны өвтэй садан төрөл байж болохоор байна. Ийм ч учраас “Жороо нь жороо”

уртын дуу үзэмчинд дуулагдаж ирсэн байх. Үүний нэгэн баталгаа нь “Бидний судалгаагаар өнөөгийн өвөр монголын цахар уртын дуу нь Хөвөөт Шараас гадна сөнөд, авга, үзэмчин уртын дууны өвөөс голлон бүрддэг нь мэдэгдэв” (Дорждагва 2019, 37) хэмээн уртын дуу судлаач М.Дорждагва дурдсан нь бидний судалгаанд олзуурхууштай дүгнэлт болж байна. Мөн Дарьгангын “Жороо нь жороо” дууг үзэмчний “Жороо нь жороо” дуутай харьцуулан судлах нь энэ дууны судалгааг дэлгэрүүлэн судлахад илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Хэлэлцүүлэг

Дарьганга уртын дууны онцлогийг судлах нь зөвхөн урлаг судлалын асуудал төдийгүй угсаатны зүй, түүх, соёлын нарийн уялдаатай асуудал болох нь дээрх судалгаануудаас харагдаж байна. Манж гүрний үед Дарьгангад суурьшсан халх, цахар, ойрад угсаатны бүлгүүдийн соёлын нийлэгжил нь дарьгангачуудын өвөрмөц хэв шинжийг бүрэлдүүлсэн бөгөөд энэ нь уртын дуунд ч тусгалаа олсон байна.

Судалгаанаас үзэхэд, дарьгангын уртын дууг зүүн зүгийн халх дэг барилд хамааруулж ангилсан хэдий ч тухайн нутгийн аялгууны ялгаатай хувилбарууд оршин байгаа нь илэрхий байна.

Гэвч аялгууны өөр хувилбаруудын харьцуулсан судалгаа хангалттай түвшинд хийгдээгүй тул цаашид дарьгангын уртын дууны аялгууны ялгаатай хувилбаруудыг нарийвчлан судлах шаардлага байна. Тухайлбал, дарьгангын өөр өөр бүс нутагт дуулагдаж буй уртын дуунуудын аялгууны бүтцийг харьцуулан судалж, дуулагдаж буй орчин, арга барилын ялгааг нарийвчлан тогтоох нь цаашдын судалгааны нэг чиглэл болох боломжтой байна. Мөн дарьгангын уртын дууны аялгууг ноотолж буулгасан баримтуудыг илүү нарийвчлан судлах нь түүхэн цаг хугацааны явц дахь аялгууны өөрчлөлтийг тогтоох ач холбогдолтой байна.

Эцэст нь дарьгангын уртын дуу нь монголын зөвхөн нэг нутгийн онцлог бус, монгол уртын дууны хөгжлийн явцад бий болсон өвөрмөц соёлын нэгэн илрэл болохыг энэхүү судалгаа харуулж байна. Иймд судалгааг улам гүнзгийрүүлэн аялгууны нарийн шинжилгээ хийх, угсаатны зүй, түүхэн баримтуудтай холбон судлах нь чухал юм.

Дүгнэлт

1. Дарьгангын “Жороо нь жороо” дуу нь тухайн нутагт өөрийн гэсэн өнгө төрхтэйгөөр биеэ даасан хувилбар болон дуулагдаж ирсэн гэж үзэж байна. Аялгууны цар хүрээ, үсрэлтийн хөдөлгөөн, тухайн нутгийн дуулах уламжлалын онцлогоороо айзам уртын дууны шинжийг хадгалсан бүтээл юм.
2. Халх болон ойрадад “Жороо баахан улаан” нэрээр дуулагдаж байгаа уртын дуу нь өөр хоорондоо шүлэг болон аялгууны хувьд ижил төстэй байгаа бөгөөд шүлгийн зарим бадгуудад нутаг нутгийн олон угсаатны онцлог зан заншлыг шингээсэн байдлаар дуулагдаж байна. Харин дарьгангын “Жороо нь жороо” дуу нь шүлгийн хувьд төстэй боловч аялгуу нь өөр байна.
3. Дарьгангын уртын дуунуудыг халх болон ойрад, өвөр монгол зэрэг бусад угсаатны дунд тархсан уртын дууны ижил төст хувилбаруудтай

харьцуулан судлах нь дарьгангын уртын дууны өв соёлыг тодруулан судлахад ач холбогдол, үр дүнгээ өгнө гэж үзэж байна.

4. Дарьгангын “Жороо нь жороо” дууг шинээр уламжлан дуулж байгаа нь ажиглагдахгүй байна. Иймд мартагдан, бүдгэрэх байдалтай байгаа учир аливаа уртын дууны тэмцээн уралдаанд дуулах уран сангийн жагсаалтад оруулж сурталчлах нь зүйтэй байна.
5. Дарьгангын уртын дуунуудад судалгаа хийснээр урт болон ардын дууны сургалтад суралцаж буй суралцагсад оюутнууд, мэргэжлийн урлагийн байгууллагын залуу үеийнхэнд өвлүүлэн үлдээх, судлаачдад гарын авлага болох ач холбогдолтой гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

- Алимаа, А., Ганболд, М., Идэрбат, Л. 2023. *Гайхамшигт Монгол уртын дуу IV боть. Монгол Улсын Зүүн бүсийн уртын дууны цоморлиг*. Улаанбаатар: Би Си Ай ХХК.
- Бөххад, Н. 2019. *Үзэмчин ардын домогт дуу*. Орч. Ариунаа Т. Улаанбаатар: Маршал принт ХХК.
- Гун-Аажав, Т. 2019. *Монгол ардын уртын дуу*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Дорждагва, Ж. 1970. *Уртын дуу*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Дорждагва, М. 2019. *Өвөр монголчуудын уртын дууны өв*. Улаанбаатар: Эрдэнэзул ХХК.
- Дорждагва, М. 2018. *Халх монголчуудын уртын дуу, зан үйл I*. Улаанбаатар: Арвай Принтинг ХХК.
- Очир, А. 2012. *Монголчуудын гарал, нэршил*. Улаанбаатар. https://esan.mn/p/mongolchuudyn-garal-nershil-43833?item_id=b2ab23ec-33f8-4f72-b0e7-eda1138d82bc.
- Оюунцэцэг, Д. 2006. *Монголын дуулалт-яруу найргийн төрөл уртын дууны гарал, хувьсал*. Улаанбаатар: Адмон.
- Сампилдэндэв, Х. Яцковская, К.Н. 1984. *Монгол ардын уртын дуу*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Туяацэцэг, Цэрэн. 2021. *Хуур магнайн эгшиг*. Улаанбаатар: Сэлэнгэ Пресс.
- Туяацэцэг, Цэрэн. 2021. *Хуур магнайн эгшиг. Ноот*. Улаанбаатар: Сэлэнгэ Пресс.
- Цолоо, Ж. 1987. *Арван гурван хүлгийн дуун*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Цэеэ-Ойдов, Д. 2022. *Дарьгангынхаа хуучуулыг дурсахуй*. Улаанбаатар: Арилдал.
- Чимэдцэеэ, Ш. 1995. *Жаахан шарга*. Улаанбаатар: Соёмбо.
- Чимэдцэеэ, Ш. 1995. *Жаахан шарга*. Ноот. Улаанбаатар: Соёмбо.

Чимэдцээ, Шар. 2024. *Дарьганга дууны хэл, соёлын онцлог*. Улаанбаатар: Нэпко.

Чулуунцэцэг, Ц. 2021. *Монгол улс дахь уртын дуу, дуучдын тархалтын судалгаа*. Улаанбаатар. https://esan.mn/p/mongol-uls-dahi-urtyn-duu-duuchdyn-tarhaltyn-sudalgaa-32380?item_id=f289abf2-10f7-472c-8ca8-4a46a33276cf.

Ярилцлага:

Ч.Шархүүхэнтэй (АЖ) хийсэн ярилцлага. Улаанбаатар хот, 2022.

С.Нансалмаа (Ц.Бүрзмаагийн охин урт дууч МУГЖ)-тай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот, 2022.